



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 01 сарын 02 өдөр

Дугаар A/02

Мандалговь

Албан тушаалын ангилал, зэрэглэл,  
цалин нэмэгдлийг шинэчлэн  
батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, 57.2.2, 57.2.4, 57.17, Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 489 дүгээр тогтоол, “Журамд өөрчлөлт оруулах тухай” 491 дүгээр тогтоол, Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолын 3,10 дугаар хавсралт, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, 4 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”, Хүн амын бодлого, Хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 тоот тушаалаар батлагдсан “Төрийн үйлчилгээний түгээмэл мэргэжлийн албан хаагчдад, ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 2 дугаар заалт, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ны 9 дүгээр журмаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2 дах заалт, “Улсын их хурлын байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.1, Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн ‘Захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгох тухай’ A/17 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- Орон нутгийн өмчийн газрын албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэл, цалин нэмэгдлийг хавсралтаар баталсугай.
- Албан хаагчдын тушаалын сарын үндсэн цалин, нэмэгдлийг хавсралтад заасны дагуу 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн тооцож олгохыг нягтлан бодогч (Э.Саранзаяа)-д зөвшөөрсүгэй.
- Албан тушаалын чиг үүргийн дагуу ажилдаа хариуцлагатай, төрийн албан хаагчийн ёс зүйг мөрдөн ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.АДЬЯСУРЭН



482412003